Монгол дахь “Уламжлалт анагаахын засалч” хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа

И.Дүүрэнжаргал[1,2], Г.Мөнхзул[2], Д.Цэнд-Аюуш[1], Н.Оюунцэцэг[1], Н.Занди[1]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг, Спорт зөөлөн эдийн гэмтлийн тасаг
Цахим шуудан: duurenjargal.i@mnums.edu.mn, Утас: 99864147

Түлхүүр үг:

Сэтгэл ханамж
Уламжлалт анагаахын засалч
Хөтөлбөр

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаахын засалч /УАЗ/ хөтөлбөр нь АШУҮИС-ийн МАУОУС нь Японы Токио Ариаке Их Сургуультай хамтран 2016 онд шинээр нээсэн хөтөлбөр юм. 2023 оны 4 сарын байдлаар УАЗ хөтөлбөрийн 3 удаагийн төгсөлтөөр нийт 52 мэргэжилтэн төгсөж, 53 оюутан суралцаж байна. Дээд боловсролын байгууллагын сургалтын үйлчилгээний чанарын нэг үзүүлэлт нь суралцагчдын сэтгэл ханамж байдаг бөгөөд суралцагчдын сэтгэл ханамж нь эргээд ирээдүйн эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн тусламж үйлчилгээний чанарын баталгаа болдог учир бид тус хөтөлбөрөөр төгсөгчид болон суралцагчдаас хөтөлбөрийн талаар үнэлгээ хийхийг зорилоо. **Зорилго:** Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгааг дескриптив судалгааны нэг агшингийн загвараар тоон судалгааны аргаар хийж гүйцэтгэсэн. Асуумж судалгаанд нээлттэй ба хаалттай асуулт хосолсон судалгааны картыг боловсруулж, УАЗ хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудаас 5 бүлэг бүхий 20 асуумж, УАЗ хөтөлбөрөөр төгсөгчдөөс 5 бүлэг 18 асуумжийг авсан. **Үр дүн:** УАЗ хөтөлбөрөөр төгссөн 50 мэргэжилтэн, УАЗ хөтөлбөрөөр суралцаж буй 50 оюутныг судалгаанд хамруулсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 22.04±2.24, хүйсийн байдлаар авч үзвэл 17% нь эрэгтэй, 83% нь эмэгтэй байв. Уламжлалт анагаахын засалч мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийн асуулгад тус мэргэжлээр суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг эсэхийг тодруулахад 28% нь дунд зэрэг, 44% нь хангалттай, 28% нь хангалттай сайн гэж хариулсан байна. Энэ үзүүлэлтийг голч утгаар илэрхийлбэл 3.63±0.92 байв. Харин уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ 3.91±0.70 байв. Тус 2 бүлгийн хооронд статистик магадлал бүхий ялгаа байхгүй байлаа (p=0.17). Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн нийт сэтгэл ханамжийн Ликертийн үнэлгээ 3.79±0.81 байсан нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш буюу сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна (p=0.0001). УАЗ хөтөлбөрөөр суралцагчдын сургалтын орчин нөхцөл сайжрах, хичээлийн агуулга уялдаа холбоотой байдал хангалттай сайн байх, сонгон судлах хичээлүүд нэмэгдэж сайжрах нь суралцагчдын сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлж, шууд хамааралтай байлаа. Суралцах мэдлэгээ эмнэлзүйд шууд хэрэглэх итгэл бага байх, сургалтын ачаалал их байх нь суралцагчдын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж, урвуу хамааралтай байгаа нь регрессийн шинжилгээгээр харагдлаа. (p=0.032). **Дүгнэлт:** Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамж Ликертийн үнэлгээгээр 3.79±0.81 байгаа нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш буюу сэтгэл ханамжтай байгааг харуулж байна (p=0.0001).

Үндэслэл: 1990 онд Анагаах Ухааны Их Сургуульд Монголын уламжлалт анагаах ухааны тэнхим байгуулагдаж байсан бол 2016 онд АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль болж өргөжиж, уламжлалт анагаах ухааны их эмч, зүү төөнө заслын эмч, уламжлалт анагаахын засалч гэсэн гурван мэргэжлээр төгсөлтийн өмнөх, төгсөлтийн ба төгсөлтийн дараах сургалтуудыг явуулж

байна. “Уламжлалт анагаахын засалч” бакалаврын хөтөлбөрийг Япон дахь Токио Ариаке Их Сургуультай хамтран 2016 оны 9 сарын 1-нд нээж, 36 оюутан анх элсэн суралцаж байсан бол 2023 оны 4 сарын байдлаар 52 мэргэжилтэн төгсөж, 53 оюутан суралцаж байна. Уламжлалт анагаахын засалч мэргэжлийн төгсөлтийн сургалтыг 2020 оны 10 сараас явуулж эхлээд байна.

УАЗ хөтөлбөрөөр төгсөгч нь Японы анагаах ухааныг Монголын уламжлалт анагаах ухаантай хослуулан уламжлалт анагаах ухааны заслын, жүдо бариа заслын, сэргээн засахын, гэмтлийн яаралтай тусламж үйлчилгээ, мөн спортын анагаах ухааны тусламж үйлчилгээг үзүүлэх чадвартай боловсон хүчин болж бэлтгэгддэг.

Жүдо бариа засал нь Японд 1400 гаруй жилийн өмнө үүсч хүний биед учирсан эмгэгийг мэс засал, эм тариа хэрэглэхгүйгээр бариа засал, сэргээн засах эмчилгээ, физик эмчилгээ, хөдөлгөөн эмчилгээ гэсэн өрнө ба дорнын анагаах ухааныг хослуулан бие махбодын өөрийгөө эдгээх чадварыг дээд хэмжээнд нь идэвхжүүлдэг уламжлалт анагаах юм.

Дээд боловсролын байгууллагын сургалтын үйлчилгээний чанарын нэг үзүүлэлт нь суралцагчдын сэтгэл ханамж байдаг бөгөөд суралцагчдын сэтгэл ханамж нь эргээд ирээдүйн эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн тусламж үйлчилгээний чанарын баталгаа болдог. Иймд Уламжлалт анагаахын засалч мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагч оюутнууд болон тус хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийн байдлыг судлахаар зорилоо.

Зорилго: Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийг үнэлэх.


Зорилт:

1. АШУҮИС-МАУОУС-ийн Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх
2. Сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьцуулан дүн шинжилгээ хийх

Арга, аргачлал: Судалгааг явуулахдаа дескриптив судалгааны нэг агшингийн загвараар тоон судалгааны аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн УАЗ хөтөлбөрөөр суралцаж буй 50 оюутан, тус хөтөлбөрөөр суралцаж төгссөн 50 төгсөгчийг тус тус хамруулав. УАЗ хөтөлбөрөөр суралцагч оюутнуудаас нээлттэй ба хаалттай асуулт хосолсон 5 бүлэг бүхий 20 асуулттай судалгааны асуумжаар, төгсөгчдөөс нээлттэй ба хаалттай асуулт хослуулсан 18 асуулттай судалгааны асуумжаар судалгааг хийж гүйцэтгэлээ. АШУҮИС, МАУОУС-ийн “Уламжлалт анагаахын засалч” хөтөлбөрөөр суралцагч оюутнууд болон төгсөгчдөөс таниулсан зөвшөөрлийг авсны үндсэн дээр google forms ашиглан судалгааг хийж, үр дүнд SPSS-27 программыг ашиглаж статистик боловсруулалтыг хийлээ.

АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 19-ний хурлаар судалгааны ажлыг хийх ёс зүйн зөвшөөрөл авсан. (Протокол № 2021/3-11)


Үр дүн: 2023 оны 4 сарын байдлаар Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрийн 3 төгсөлтөөр нийт 52 мэргэжилтэн төгссөнөөс судалгаанд 50 мэргэжилтэн, УАЗ хөтөлбөрөөр суралцаж буй 50 оюутныг тус тус судалгаанд хамруулсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 22.04±2.24, эрэгтэйчүүдийнх 22.42±0.49, эмэгтэйчүүдийнх 21.93±0.32 байлаа. Хүйсийн байдлаар авч үзвэл 17% нь эрэгтэйчүүд, 83% нь эмэгтэйчүүд байв. (Зураг 1)



Зураг 1. Судалгаанд оролцогчдын дундаж нас, хүйсийн байдал


Уламжлалт анагаахын засалч мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийн асуумжид тус мэргэжлээр суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг эсэхийг тодруулахад 28% (n=14) дунд зэрэг, 44% (n=22) нь хангалттай, 28% (n=14) хангалттай сайн гэж хариулсан байна. Энэ үзүүлэлтийг голч утгаар илэрхийлбэл 3.63±0.92 байв. Харин уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ 3.91±0.70 байв. Тус 2 бүлгийн хооронд статистик магадлал бүхий ялгаа байхгүй байлаа (p=0.17).

Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамж Ликертийн үнэлгээгээр 3.79±0.81 байгаа нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш буюу сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна (p=0.0001). (Зураг 2)




Зураг 2. УАЗ хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамж

УАЗ хөтөлбөрөөр суралцагчдын сургалтын орчин нөхцөл сайжрах, хичээлийн агуулга уялдаа холбоотой байдал хангалттай сайн байх, сонгон судлах хичээлүүд нэмэгдэж сайжрах нь суралцагчдын сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлж, шууд хамааралтай байлаа. Суралцах мэдлэгээ эмнэлзүйд шууд хэрэглэх итгэл бага байх, сургалтын ачаалал их байх нь суралцагчдын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж, урвуу хамааралтай байгаа нь регрессийн шинжилгээгээр харагдлаа. (Зураг 3)




Зураг 3. Суралцагчдын сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлүүд

Төгсөгчдийн асуумжид сургалтын орчин нөхцөл нь суралцах идэвхтэй шууд хамааралтай байгаа эсэхийг тодруулахад сургалтын орчин нөхцөл сайжрах тусам суралцах идэвх сайжирч байв (p=0.032). (Зураг 4)



Зураг 4. Сургалтын орчин нөхцөл ба суралцах идэвхийн хамаарал

Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрийн төгсөгчдийн сургалтын үр дүн, зохион байгуулалтын асуумжид хөтөлбөрийн агуулга 50% (n=25) хангалттай, 20% (n=10) хангалттай сайн, 30% (n=15) дунд зэрэг. Сургалтын уялдаа холбоо 60% (n=15) хангалттай, 10% (n=5) хангалттай сайн, 30% (n=15) дунд зэрэг гэж үнэлсэн байна. (Зураг 5)



Зураг 5. Сургалтын үр дүн, зохион байгуулалт

Хэлцэмж: Уламжлалт анагаахын засалч мэргэжил нь Монгол улсын хувьд 2016 онд шинээр бий болсон хөтөлбөр бөгөөд өнөөгийн байдлаар 50 оюутан төгссөн. Уламжлалт анагаахын засалч мэргэжлээр суралцагчдын 72% (n=36), төгсөгчдийн 70% (n=35), ажил олгогч нарын 96% (n=48) сэтгэл ханамж өндөртэй байгаа нь тус хөтөлбөрөөр суралцан төгсөгчдийн хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байна.

Төгсөгчдөд ажил олдохгүй байгаа шалтгаан нь ажилд ороход ажлын туршлагагүй 44% (n=22), ажлын байр хомс 28% (n=14), хэлний мэдлэг муу 12% (n=6), ажил олгогч нар уламжлалт анагаах засалч мэргэжлийн талаар оновчтой ойлголт байхгүй, уламжлалтын сувилагч, сэргээн засахын сувилагч гэсэн ойлголттой байгаа нь 62% (n=31)-ийг эзэлж байгаа нь тус мэргэжлийг эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд болон эмнэлгийн мэргэжилтнүүд, элсэгчдэд таниулан сурталчлах ажлыг хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны асуумжийн хариултад илэрхийлэх тоон утга болоод Ликертийн үнэлгээнээс үзвэл "Уламжлалт анагаахын засалч" мэргэжлийн төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэ мэргэжлийг таниулан сурталчлах ажлыг хийх шаардлагатай байна.

Судалгааны сургалтын үр дүн зохион байгуулалтын бүлэг асуумжийн үр дүнгээс үндэслэн Япон багш нартайгаа харилцаж ойлголцоход Япон хэлний бэрхшээл тулгарч байгаатайгаар Япон хэлний хичээлийн сонгон хичээлийн цагийг нэмэгдүүлэн, мэргэжлийн хэлний багш нараар оруулах нь саналтай байна.

Ө.Ариунжаргал (2022) нарын Уламжлалт анагаах ухааны их эмчээр суралцагч, оюутнуудын сэтгэл ханамжийн үнэлгээ нь дунджаас дээгүүр байсан нь бид нарын судалгааны үр дүнтэй орйолцоо байлаа.

Дүгнэлт: Уламжлалт анагаахын засалч хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамж Ликертийн үнэлгээгээр 3.79±0.81 байгаа нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш буюу сэтгэл ханамжтай байгааг харуулж байна (p=0.0001).

Ном зүй:

1. *Д.Цэнд-Аюуш, Т.Алимаа, Б.Цэрэнцоо, Ч.Батнайрамдал, Б.Баярмаа "Монголын уламжлалт анагаах ухааны онол" УБ. 2017 х18-19*
2. *Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль Д.Цэнд-Аюуш, Н.Оюунцэцэг, Н.Төмөрбаатар, Т.Алимаа "Монгол анагаах ухааны засал" УБ. 2017 х9-12*
3. *Нэмото Цүнэо, Ямагүчи Тооичиро, Хаякава Масая, Канай Хидэки, Камеяама Минору "Эмнэлзүйн жүдо бариа засал (Японы уламжлалт анагаах ухаан)" УБ. 2014 х4-5*
4. *What is Judo therapy? www.kyobun.ac.jp*
5. *Juriang Ma Xiaole Guo Atang Xu Jiyu Zhang Chongqi Hia Epidemiological analysis et injury Shandong Province China BMC PublicHealth 2008 8-22*
6. *Japanese Ministry of Internal Affairs and Communications Judo Therapist*
7. *Нямдаваагийн Энхжаргал "Уламжлалт анагаахын бакалаврын боловсрол олгох сургалтын цөм төлөвлөгөө" АУ-ны магистрын зэрэг горилсон бүтээл УБ. 2005*
8. *https://www.tau.ac.jp/*
9. *http://www.jusei.or.jp/tech/english/whatisjudotherapy.html*
10. *Р.Бонита, Р.Биглхол, Т.Кжелстром "Эпидемиологийн үндэс" хоёр дахь хэвлэл*
11. *М.Пүрэвжав Монголын уламжлалт анагаах ухааны судалгааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжлэл АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл УБ.2014*
12. *Kanai Hedeki Эмнэлзүйн Жүдо бариа засал 2014 х4-5*
13. *Japanese ministry of healt. Labour Welfare: The costs of judo therapy, massage therapy, acupuncture and moxibustion.*
14. *Ө.Ариунжаргал Уламжлалт анагаах ухаан 2+4 хөтөлбөрөөр суралцагчдын үнэлгээ АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл УБ. 2022*

Students' and graduates satisfaction survey result of the "Traditional Medical Therapist" curriculum

Duurenjargal I[1], Munkhzul G[2], Tsend-Ayush D[1], Oyuntsetseg N[1], Zandi N[1]

[1]Department of Traditional Bariatric Surgery, International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Department of sports and soft tissue injuries, Mongolian Medical Central Hospital, ISMM
E-mail: duurenjargal.i@mnums.edu.mn, Tel: +976-99864147

Background: The Traditional Medical Therapist /TMT/ program is a new program opened in 2016 by the MNUMS of TMT in collaboration with Tokyo Ariake University in Japan. As of April 2023, a total of 52 specialists have graduated in three rounds of the TMT program and 53 students are studying. One of the indicators of the quality of educational services in higher education institutions is student satisfaction, and student satisfaction, in turn, is a guarantee of the quality of care provided by future health professionals.
Aim: To assess student satisfaction with traditional medical therapist programs.
Materials and Methods: The study was conducted using an analytical survey design. In the survey, a survey card with a combination of open and closed questions was developed, and 20 questionnaires with 5 groups were collected from students studying in Mongolia under the TMT program and 18 questionnaires with 5 groups were collected from graduates.
Results: 50 specialists who graduated from the TMT program and 50 students studying under the TMT program were included in the study. The average age of the participants was 22.04±2.24 years, and 17% were male and 83% were female. In the satisfaction questionnaire of traditional medicine healers, 28% answered moderately, 44% fair, and 28% good. The mean value of this indicator was 3.63±0.92. On the other hand, the satisfaction rating of graduates of the traditional medical therapist program was 3.91±0.70. There was no statistically significant difference between the two groups (p=0.17). The Likert rating of the overall satisfaction of students and graduates of the traditional medical therapist program was 3.79±0.81, which indicates that the level of satisfaction is above average or satisfactory (p=0.0001). TMT program improved the learning environment of the students, the coherence of the course content was good enough, and the increase in the number of elective courses had a positive effect on the satisfaction of the students and was directly related. Regression analysis showed that there is an inverse relationship between the lack of confidence to directly apply the knowledge learned in the clinic and the high learning load negatively affecting the satisfaction of students. (p=0.032).
Conclusion: The satisfaction of students and graduates of the traditional medical therapist program is 3.79±0.81 according to the Likert scale, which indicates that the level of satisfaction is above average or satisfactory (p=0.0001).

Keywords: Satisfaction, Traditional medical therapist, Program